



Үг. С.Асарсайхан

Ая. Д.Ганхуяг

ЭРДЭНЭДАЛАЙ МИНИЙ НУТАГ

/Сумын сүлд луу/

Хул- тай — айр-ганд нь уруу - л чимч-гэнэ - сэн

5
Хуур - ын аял-гуунд нь сүрэг нь ө - с - сөн

9
Дугараа барь - ж түр - лэг — өргө - сөн

11
Дүүрэн — заяа - тай түм - ний ө - л - гий

14
Эхийн сэт - гэл шиг өг - өөж баян —

16
Эрд- энэ — дал - ай мин - ий ну - т - гаа

Хултай айрганд нь уруул чимчигнэсэн
Хуурын аялгуунд нь сүрэг нь өссөн
Дугараа барьж түрлэг өргөсөн
Дүүрэн заяатай түмний өлгий

Эхийн сэтгэл шиг өгөөж баян
Эрдэнэдалай миний нутаг

Буян хурсан даншиг наадмын
Дархан түрүү түмэн эхтэй
Бодол хөглөж найр жаргаасан
Далай шиг цалгисан цэнхэр нутаг аа

Эхийн сэтгэл шиг өгөөж баян
Эрдэнэдалай бидний нутаг

Алсын зэрэглээ угалзрах нутагтаа
Алдарт баатрууд малчдын хийморьтой
Агь таанат цахиурт талууд нь
Адууны тэнгэртэй өлгий нутаг аа

Эхийн сэтгэл шиг өгөөж баян
Эрдэнэдалай түмний нутаг



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 81

Сангиндалай

Сумын сүлд дууг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дүгээр заалтыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын сүлд дуугаар Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан С.Асарсайханы шүлэг, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Д.Ганхуягийн хөгжим, "Эрдэнэдалай миний нутаг" дууг сонгож, хавсралтаар баталсугай.

2. Сумын сүлд дууг нийтэд хүртээл болгох ажлыг зохион байгуулж, сурталчлан таниулахыг сумын Засаг дарга (Б.Лхагвамандал), сумын Соёлын төвийн эрхлэгч (Ө.Эрдэнэчимэг)-т даалгасугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН